



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/100/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15



1.Хараат бус аудиторын дүгнэлт



Г ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН Т
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭНХБААТАР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.17 № 54

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Т

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Статистикийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Статистикийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Статистикийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020032



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,325,794.00</u>	<u>4,325,794.00</u>
33	АВЛАГА	00.00	1,109,332.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	00.00	1,109,332.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,325,794.00	4,325,794.00
354	Хангамжийн материал	4,325,794.00	4,325,794.00
35420	Аж ахуйн материал	1,942,578.00	1,942,578.00
35470	Бусад хангамжийн материал	2,383,216.00	2,383,216.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,929,635.42</u>	<u>61,043,275.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,929,635.42	61,043,275.94
392	Биет хөрөнгө	3,929,635.42	61,043,275.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	19,980,000.00	55,730,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,787,750.00	-23,757,972.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,836,082.64	51,128,063.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,517,891.64	-22,243,343.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,490,160.00	5,490,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,070,965.58	-5,303,631.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	457,787.00	457,787.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-457,787.00	-457,787.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,255,429.42</u>	<u>66,478,401.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,109,332.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,109,332.00
413	Өглөг	00.00	1,109,332.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,255,429.42</u>	<u>65,369,069.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,255,429.42	65,369,069.94
512	Хуримтлагдсан үр дүн	8,255,429.42	65,369,069.94
51210	Өмнөх үеийн үр дүн	8,255,429.42	8,255,429.42
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	57,113,640.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,255,429.42</u>	<u>66,478,401.94</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	266,027,219.70	401,398,229.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	61,041,981.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	61,041,981.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	61,041,981.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	61,041,981.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	266,027,219.70	340,356,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	89,989,400.00	103,808,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	89,989,400.00	103,808,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	176,037,819.70	236,547,648.00



131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,300,000.00	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,267,819.70	227,547,648.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	287,192,631.70	344,284,588.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,192,631.70	344,284,588.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,737,605.20	341,616,960.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,085,638.50	87,291,390.40
210101	Үндсэн цалин	56,612,106.50	57,147,819.74
210102	Нэмэгдэл	13,861,429.00	21,074,897.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,612,103.00	3,357,000.00
210104	Урамшуулал	00.00	5,711,673.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,310,873.00	10,430,404.27
210201	Тэтгэврийн даатгал	6,487,383.00	10,430,404.27
2104	Хангамж, бараа материалын зардал	2,215,995.00	1,805,380.00
210401	Бичиг хэрэг	527,745.00	619,400.00
210402	Тээвэр, шатахуун	795,200.00	213,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	803,350.00	619,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	89,700.00	353,380.00
2107	Томилолт, зочны зардал	759,300.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	759,300.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,223,786.70	233,954,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,956,486.70	233,046,469.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	81,676.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	39,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	787,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,178,012.00	7,928,340.48
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,633,512.00	7,928,340.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,455,026.50	2,667,628.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	221,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	221,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,155,026.50	2,446,228.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,155,026.50	2,446,228.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-21,165,412.00	57,113,640.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-21,165,412.00	57,113,640.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	284,559,119.70	340,356,248.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	284,559,119.70	340,356,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	89,989,400.00	103,808,600.00



131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	89,989,400.00	103,808,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	194,569,719.70	236,547,648.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,145,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,300,000.00	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,799,719.70	227,547,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	325,000.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	284,559,119.70	340,356,248.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,559,119.70	340,356,248.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,104,093.20	337,664,019.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,155,529.50	87,900,142.40
210101	Үндсэн цалин	52,997,529.50	56,692,282.74
210102	Нэмэгдэл	17,642,800.00	19,299,187.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,200.00	3,357,000.00
210104	Урамшуулал	00.00	8,551,672.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,240,982.00	10,321,652.27
210201	Тэтгэврийн даатгал	6,244,574.00	10,321,652.27
210202	Тэтгэмжийн даатгал	757,993.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	240,803.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480,100.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,517,512.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,215,995.00	2,437,180.00
210401	Бичиг хэрэг	527,745.00	509,400.00
210402	Тээвэр, шатахуун	795,200.00	845,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	803,350.00	619,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	89,700.00	463,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	964,000.00	00.00
210604	Урсгал засвар	964,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	759,300.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	759,300.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,223,786.70	236,798,045.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,956,486.70	235,890,069.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	81,676.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	39,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	787,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,455,026.50	2,692,228.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	246,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,155,026.50	2,446,228.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,155,026.50	2,446,228.33



3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	00.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,410,841.42	00.00	29,410,841.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	29,410,841.42	00.00	29,410,841.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,155,412.00	00.00	-21,155,412.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	8,255,429.42	00.00	8,255,429.42



D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	8,255,429.42	00.00	8,255,429.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	8,255,429.42	00.00	8,255,429.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	57,113,640.52	00.00	57,113,640.52
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	65,369,069.94	00.00	65,369,069.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,989,400.00	89,041,606.50	104,008,600.00	101,519,950.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,989,400.00	89,041,606.50	104,008,600.00	101,519,950.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,689,400.00	88,741,606.50	103,762,600.00	101,273,950.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,025,600.00	73,155,529.50	87,432,600.00	87,400,142.40
210101	Үндсэн цалин	53,867,600.00	52,997,529.50	57,758,500.00	56,692,282.74
210102	Нэмэгдэл	17,642,800.00	17,642,800.00	20,512,000.00	19,299,187.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,545,200.00	2,515,200.00	4,579,200.00	3,357,000.00
210104	Урамшуулал	00.00	00.00	4,582,900.00	8,051,672.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,253,300.00	9,240,982.00	11,803,400.00	10,321,652.27
210201	Тэтгэврийн даатгал	6,292,200.00	6,244,574.00	8,306,000.00	10,321,652.27
210202	Тэтгэмжийн даатгал	740,300.00	757,993.00	874,300.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	592,200.00	240,803.00	699,500.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	148,100.00	480,100.00	174,900.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,480,500.00	1,517,512.00	1,748,700.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,217,000.00	2,215,995.00	2,469,800.00	2,437,180.00
210401	Бичиг хэрэг	452,900.00	527,745.00	541,400.00	509,400.00
210402	Тээвэр, шатахуун	795,200.00	795,200.00	845,000.00	845,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,300.00	803,350.00	619,400.00	619,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133,600.00	89,700.00	464,000.00	463,380.00



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,015,500.00	964,000.00	328,800.00	00.00
210604	Урсгал засвар	1,015,500.00	964,000.00	328,800.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	772,200.00	759,300.00	207,000.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	772,200.00	759,300.00	207,000.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,861,300.00	1,861,300.00	1,318,300.00	907,976.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	243,500.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	198,000.00	81,676.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	49,500.00	49,500.00	39,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	19,800.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,000,000.00	807,500.00	787,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544,500.00	544,500.00	202,700.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00	202,700.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00	246,000.00	246,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00	246,000.00	246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	246,000.00	246,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,989,400.00	89,989,400.00	104,008,600.00	103,808,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	89,989,400.00	89,989,400.00	104,008,600.00	103,808,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	89,989,400.00	89,989,400.00	104,008,600.00	103,808,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	07.00	07.00	07.00	07.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00	04.00	04.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	02.00	02.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	07.00	07.00	07.00	07.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	05.00	05.00	05.00	05.00
650010	Гэрээт ажилтан	02.00	02.00	02.00	02.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		236,390,069.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		236,390,069.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		236,390,069.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		500,000.00
210104	Урамшуулал		500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		235,890,069.00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		235,890,069.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		236547648.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		236,547,648.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		227,547,648.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Энхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 01 дүгээр сарын 29-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Статистикийн тооллого, судалгаа зохион байгуулах, эдийн засгийн салбарын мэдээлэл, цуглуулах, боловсруулах тархаах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Статистикийн хэлтэс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Статистикийн хэлтсийн 2020 онд хийсэн хүн амын тооллого, өрхийн нийгэм, ажиллах хүчний судалгаа, хөдөө аж ахуйн ашиг шимийн гарцын судалгаа, мал тооллогын ажлыг Үндэсний



статистикийн хорооны тооллого судалгааг хариуцсан алба, хэлтсүүд нь санхүүгийн баримт, бүртгэл, судалгааг цахимаар татан авч шалгасан байна. Шалгалтаар алдаа зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Статистикийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 287,182.6 мянган төгрөгөөс тооцон 5,743.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,885.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Статистикийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,223.0 мянган төгрөгөөр буюу 8 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	1,109.3	1,109.3
Урьдчилгаа			
Бараа материал	4,325.8	4,325.8	0
Үндсэн хөрөнгө	48,264.0	113,306.0	65,042.0
Элэгдэл	-44,334.4	-52,262.7	-7,928.3
Нийт хөрөнгө	8,255.4	66,478.4	58,223.0
Өр төлбөр	0	1,109.3	1,109.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,255.4	65,369.1	57,113.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,255.4	66,478.4	58,223.0

Авлага дансны үлдэгдэл 1,109.3 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 113,306.0 мянган төгрөг болж 65,042.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 35,750.0 мянган төгрөгийн автомашин, ҮСХ-ны зөвшөөрлөөр нэмэлт данснаас авсан 4,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ҮСХ-ноос үнэ төлбөргүй шилжиж ирсэн 25,291.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж авсан зэргээс шалтгаалсан байна.



Үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,109.3 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 65,369.1 мянган төгрөг болж 57,113.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүй хөрөнгө авсантай холбоотой байна.

Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 135,374.0 мянган төгрөгөөр буюу 50,8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого болон урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна. Энэ нь үнэ төлбөргүй автомашин, тоног төхөөрөмж авсан болон цалин хөлс нэмэгдсэн, нэмэлт дансны хүн ам, орон сууц, нийгмийн болон хөдөө аж ахуйн тооллого, судалгааны санхүүжилт өссөн зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 57,102.0 мянган төгрөгөөр буюу 19,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, хүн ам, орон сууц, нийгмийн болон хөдөө аж ахуйн тооллого, судалгааны зардлууд гарсан байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмсэн, нэмэлт дансны хүн ам, орон сууц, нийгмийн болон хөдөө аж ахуйн тооллого, судалгааны зардал өссөн зэргээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 104,008.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 104,008.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагч нь хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-70405/ хөтөлбөрийн 1 /код-80101/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 104,008.6 мянган төгрөгийг улсын төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 103,808.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 101,519.9 мянган төгрөгийг зарцуулж, 2,288.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 101,519.9 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 1,514.2 мянган төгрөгөөр, Эд хогшил худалдан авах зардлыг 328.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 410.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 35.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 70405 хөтөлбөрийн 80101 арга хэмжээний 2,288.7 мянган төгрөгийг дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 227,547.6 мянга нийт 236,547.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 235,890.1 мянга, урамшуулалд 500.0 мянга нийт 236,390.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 157,5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 81,895.5 мянган төгрөгийн 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 27,800.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	27,800.9	1	27,800.9			0
Зөвлөмж							
Нийт дүн	1	27,800.9	1	27,800.9			0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,109.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,109.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ.

Залруулсан алдаа

Аудитаар ХХОАТ-тай холбоотой 1,109.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 81,895.4 мянган төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 1,109,3 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:



1. Статистикийн хэлтэс 45,910.0 мянган төгрөгийн орлогын, 35,985.4 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 1,109,3 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Статистикийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/100/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 1109,3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авсан	1,109.3	Албан шаардлага	Дарга	Д.Энхбаатар
2	45,9 сая төгрөгийн орлогын, 35,9 сая төгрөгийн зарлагын мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан	81,895.4	Албан шаардлага	Нягтлан бодогч	Д.Энхбаатар
ДҮН		83,004.7			